



ЧИХ, ХАМАР, ХООЛОЙ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Чих, хамар, хоолойн мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, хэвлэлийн тойм, судалгаа, ховор тохиолдол, лекц, зөвлөгөө гэх мэт эрдмийн ажлыг 3-аас доошгүй удаа хэвлүүлсэн байх;
2. Чих, хамар, хоолойн мэс засал хийх онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байх, мөн мэс заслын заалт гаргах мэс заслын дараах асаргаа, хяналт хийх чадвартай байх /тонзиллэктоми, трахеостоми, сонсгол тэнцвэрийн сорил шинжилгээ хийж дүгнэх, ялган оношлох /калдвелл-люка, парацентез, tube insertion гэх мэт/ ;
3. Сургалт эрхлэгч байгууллагаас / мэргэжлийн нийгэмлэг, холбоо / зохион байгуулсан үндэсний хурал болон төгсөлтийн дараах сургалтад 5 ба түүнээс олон удаа хамрагдсан байх;
4. Гадаадад мэргэшил дээшлүүлснийг нэг удаагийн эрдмийн ажилтай дүйцүүлэн тооцох;
5. Дотоодын мэргэшил дээшлүүлэх сургалтад 2-оос доошгүй удаа хамрагдсан байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүн амд чих, хамар, хоолойн шинжлэх ухааны онош, эмчилгээний тусламжийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол, дадлагын мэдлэгтэй, сургалт явуулах чадвартай, бүтээлтэй байх;
2. Чих, хамар, хоолойн нөхөн сэргээх хагалгааны онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байх /тимпанопластика, септопластика, ринопластика, микроларингоскопи, төвөнхийн болон хамар чихний өргөтгесөн мэс засал, оношилгооны CT, MRI, BERA гэх мэт сонсгол тэнцвэрийн бүх шинжилгээ/ ;
3. Чих, хамар, хоолойн мэргэжлийн сэтгүүлд хэвлэлийн тойм, ховор тохиолдол, лекц, эрдэм шинжилгээний өгүүлэл, зөвлөгөө, орчуулга, судалгаа гэх мэт эрдмийн ажлыг ахлах зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй удаа хэвлүүлсэн байх;

4. Сургалт эрхлэгч байгууллагаас / мэргэжлийн нийгэмлэг, холбоо / зохион байгуулсан семинарт ахлах зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй удаа хамрагдсан байх;
5. Мэргэшил дээшлүүлэх гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан байх;
6. Мэргэшлийн чиглэлийн дагуу сургалт, семинар зохион байгуулсан байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний ажил удирдах чадвартай, оюуны бүтээлтэй байх;
2. Чих, хамар, хоолойн нөхөн сэргээх бичил мэс засал хийх онолын мэдлэгтэй буюу ур чадвартай байх /гадна, дунд, дотор чихний бичил мэс засал, суулгацын мэс засал, гавал тархины хүндрэлийн үеийн мэс засал, нээлттэй риносептопластика, ларингоэктоми, ларинготрахеопластика гэх мэт /;
3. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулах үндэсний хуралд багшилж, сургалт зохион байгуулсан байх;
4. Нийгэмлэгийн болон бусад сэтгүүлд эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл 15-аас доошгүй удаа хэвлүүлсэн байх;
5. Гадаад оронд мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, олон улсын чанартай томоохон сэтгүүлд нэгдүгээр нэрээр өөрийн бүтээлийг нийтлүүлсэн байх;
6. Сонсгол болон тэнцвэрийн зөвлөх эмч нь тухайн чиглэлээр 3-аас доошгүй эмч мэргэжилтэн бэлтгэсэн байх.